



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/26

Сүхбаатар сум

### Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “г”, 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.17, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.5 дахь хэсэг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруунбүрэн сумын “Хөшөөтийн доод ам” нэртэй 54.95 гектар талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн 15 жилийн хугацаатайгаар “Дархан молор Эрдэнэ” ХХК-д олгосугай.


2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулахыг түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Дархан молор Эрдэнэ” ХХК /Т.Мөнхзул/-д зөвлөсүгэй.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд холбогдох хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /З.Түвшинтөгс/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Баттүвшин/, Баруунбүрэн сумын Засаг дарга /Ц.Сэлэнгэ / нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ



Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
 2021 оны 12-р сарын 1-ний өдрийн  
 1126 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

Захиргааны шийдвэрийн хувийн хэрэгт  
 хавсаргах нотлох баримт бичгийн товъёг

Д/д	Аж ахуй нэгжийн нэр	Ригестрийн дугаар	Өргөдөл	Татварын тодорхойлолт	Улсын бүртгэлийн гэрчилгээн ий хуулбар	Ашиглагч болон үлдэх талбайн зураг	Төлбөрийн баримт	Эрдэс баялагын зөвлөлийн тэмдэглэл	Тайлангийн нөөцийн зураг	Сумын Засаг даргын тодорхойлолт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	Хайгуулын тусгай зөвшөөрөл эх хувь	Ашигт малтмал, газрын тосны гарын даргын тушаал	Нийт
1	Дархан Молор-Эрдэнэ	2774771	3	1	1	2	2	5	8	1	4	2	1	30

Тайлбар: Энэхүү захиргааны шийдвэрийн хувийн хэрэгт хавсаргах нотлох баримт бичиг ХОХБТ Хэлтэст Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувийн хэрэгт хавсарган хадгалагдана.

Товъёг гаргасан:  
 ХОХБТХ Мэргэжилтэн М.Эрдэнэтогтох  
 Хянасан:  
 ХОХБТХ Дарга А.Эрдэнэгэрэл